



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/575

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Үр жимс" ХХК-ийн гүйцэтгэсэн Ховд аймгийн Манхан сумын Төгрөг гол багт цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилгоор ойн зурвас байгуулах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Л.Батбаяр - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд: Д.Бөхболд - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
ойн асуудал хариуцсан мэргэжилтэн

Э.Хосбаяр - Сум дундын ойн ангийн мэргэжилтэн

С.Данзансүрэн - Манхан сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Д.Цэндсүрэн - "Үр жимс" хоршооны дарга

Нарийн бичгийн

дарга: Х.Баасанхүү - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Үр жимс" ХХК-ийн гүйцэтгэсэн Ховд аймгийн Манхан сумын Төгрөг гол багт цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилгоор ойн зурвас байгуулах ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Л.Батбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Т.ЖАРГАЛСАЙХАН

Zah A/575 Kh
02 2319